



БҮРТГЭСЭН ХАНДАЛТ 436↑ (сүвгаар)

УТСААР
295↑



Суваг	2024	2025
	08.21	
☎	432	295
👤	21	13
🌐	24	37
✉	52	21
✉	26	55
💬	21	15
#	576	436


Нийт дуудлага
979↓

Хүлээн авсан дуудлага
295↑

Дуудлага авсан
33.3%↑

eMongolia-д шилжүүлсэн – 96↓
Алдсан дуудлага – 590↓

ХАМГИЙН ОЛОН ХАНДАЛТ АВСАН БАЙГУУЛЛАГА



ХАМГИЙН ОЛОН ХАНДАЛТ АВСАН АСУУДАЛ



ӨНӨӨДРИЙН ОНЦЛОХ 3 АСУУДАЛ

ОНЦЛОХ АСУУДАЛ-1

Улаанбаатар-Дундговь аймаг хүртэлх авто замд засвар үйлчилгээ хийж өгөхийг хүсэж байна. Авто зам эвдрэл ихтэй том том нүхтэй шороотой автомашин зорчиход хүндрэлтэй байгаа тул яаралтай засаж өгөхийг хүсэж байгаа талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-2

СХД-2, "Шинэ толгойт" хорооллоос холбогдож байна. 102, 106 дугаар байр халуун усгүй 5 сар гаран болоод явж байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад нь уламжлан шийдвэрлэж, тодорхой хариуг авах талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-3

БГД-4, 10-р байрны дулааны шугам гэмтээд 10 хонож байгаа бөгөөд арга хэмжээ авахгүй байна. 10-аад хоног шийдэхгүй байж одоо замын зөвшөөрөл авна гэсэн тайлбар өгч байгаа талаар

ШИЙДВЭРЛЭЛТ:

257↑

Хүснэгт: 2025.08.21-ийн өдөр тутмын мэдээлэл

Хүснэгт: 2025.08.21-ийн өдөр тутмын мэдээлэл

ХАМГИЙН ИХ ХАНДАЛТ АВСАН АСУУДАЛ: ОНЦЛОХ ГОМДОЛ

НИЙГМИЙН ДААТГАЛ

- Баянхонгор аймгийн нийгмийн даатгалд ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ өгсөн боловч хуваарийн дагуу тэтгэмж олгогдохгүй байна. Тэтгэмжээ авах хүсэлтэй байна. Яаралтай шийдвэрлэж өгнө үү.
- 2024 оны 12 дугаар сард миний тэтгэвэр 2 удаа андуурагдаад орсон. Гэтэл үүнээс болоод НДГ-аас тэтгэврийг 2 сар шилжүүлэхгүй, мөн дансыг хааснаас болоод банк дээр ангилал буурах гэж байна гэж мэдэгдээд байна. Хуваарь гаргаад төлөлт хийх маягаар шийдвэрлэж, иргэнд хүндрэлгүйгээр зохицуулах боломж байдаггүй юу. Энэ асуудлыг холбогдох дээд газарт нь уламжилж өгнө үү.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ХААГЧДЫН ХҮНД СУРТАЛ

- СХД-ийн Баянхошууны эцсийн 3-р амбулаторид хүүхдээ үзүүлэхээр ирсэн боловч, эмнэлгийн эмч нар ажлын цагаар байрандаа байхгүй байгаад гомдолтой байна. Тус эмнэлэгт 2025.08.20-нд 15:30 цагийн байдлаар нэг ч эмч байхгүй байна.
- 2025.08.03-ны өдөр e-Mongolia-гаар "Цагдаагийн байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл өгөх" гэх үйлчилгээг ашиглан гэмт хэргийн хохирогч болсон тухайгаа мэдээлсэн боловч одоог хүртэл ямар нэгэн арга хэмжээ авагдаагүй, надтай цагдаагийн байгууллагаас холбогдоогүй байна. e-Mongolia дээр миний мэдээллийг хүлээн авсан, холбогдох байгууллагад илгээсэн гэж байгаа ч шийдвэрлэлтийн явц 0 гэж гарч ирж байна. Энэ талаар e-Mongolia-тай холбогдож асуухад манайх шилжүүлэх үүрэгтэй ажлаа хийсэн байна гэж мэдээлсэн. Мөн e-Mongolia дээрх ЦЕГ-ын 7019-1060 дугаараар холбогдож тодруулахад "манайх мэдэхгүй, e-Mongolia мэдэх асуудал байна" гэдэг хариулт өгч байна. Иймд энэ асуудлыг холбогдох газар нь мэдээлж, аль байгууллага нь хариуцах талаар мэдээллийг өгч ажиллана уу.

АВТО ЗАМ

- Олон газар зам сэтлэх, тог татах, ус зайлуулах хийх гэх мэтээр зарим байгууллагууд замыг эвдээд засахгүй орхиж байгаа нь, эсвэл зассан нэртэй сайхан замыг хонхорхой болгон орхиж байгаа нь харамсалттай байна. Мөн шинээр хийсэн замынх нь траншейний нүх доошоо сууснаар машин тойрч гарах зэргээр осол гарах нөхцөлийг бүрдүүлж байна. ХУД "Токио таун"-ны хойно, "Вега сити"-гийн урд талд траншейний нүх доошоо 20 см суусан байна. ХУД "120 Мянгат"-ын уулзварын зүүнээс баруун тийш явах уулзвар дээр (Хурд талаас) бохирын эсвэл ус зайлуулах эсвэл системийг засах зорилгоор замыг ухан орхиод 10-аад хонож байна. Засаж байгаа зүйл огт байхгүй. Нарны замын зүүн тийш явах чиглэл, хүүхдийн паркийн баруун урд энхтайвны гүүрний зүүн талд байх нүхэн гарцны зүүн талд нарны замыг дөнгөж шинэчилсний дараа зам сэтэлж ухсан боловч асфалтийг хонхорхой хийж чанарыг муутгаж донсолгоотой зам болгосон. Үүнийг шалгадаг үздэг байгууллага нь яагаад хүлээж авсан бэ? СБД-5, Нарны замын хойд тал буюу эмийн үйлдвэрийн урд усны шугам хоолой зассаны дараа замыг сэтлэн засварлахгүй байсаар л байна. Энэ мэтчилэн эдгээр асуудлыг шийдвэрлэж буруутай этгээдээр замыг засварлуулан хэвийн байдалд оруулж өгнө үү.
- БЗД-33, Шар хоолойн аманд 2 км засмал замыг 2024 оноос хойш хийж байгаа юм. 06 дугаар сард оршин суугчид гомдол өгсний дагуу баяр наадмаас өмнө засаж өгнө гэсэн мэдэгдэл хийсэн. Баяр наадмын өмнө засагдахгүй байхаар нь лавлаж асуутал 2025.08.20-ны өдөр хүлээлгэж өгнө гэсэн боловч өнөөдрийг хүртэл нэмж хийгдсэн зүйлгүй яг л хэвэндээ байна. Уг асуудлыг шалган шийдвэрлэж, холбогдох газарт нь уламжилж өгнө үү.

БАЙР, ОРОН СУУЦ

- БЗД-ийн Онцгой байдлын албаны албан хаагчдын "Онцгой" хотхонд 2017 онд байр захиалсан боловч одоог хүртэл тус орон сууц баригдахгүй өдийг хүрлээ. Тус асуудлаар удаа дараа захиалагч нар Онцгой байдлын ерөнхий газарт өргөдөл өгсөн боловч асуудлыг хүлээн авч шалгахгүй барилгын явцын талаар мэдээлэл утсаар өгөөд, хааж өдийг хүрлээ. Уг асуудлыг яаралтай шалгаж арга хэмжээ авч өгөхийг хүсэж байгаа тул холбогдох газарт уламжилж өгнө үү.
- БГД-3, "Орчлон констракшн" 2022 онд 100 хувь төлбөрөө төлж байр захиалсан юм. Гэтэл одоог хүртэл ашиглалтад орохгүй анхны зураг төслөөс зөрүүтэй зураг харуулаад маш их хүндрэлтэй байна. Захиалагч нараа хохироож байгаа асуудлаар шалгаж арга хэмжээг авч өгнө үү.

ЯВГАН ХҮНИЙ ЗАМ

- "120 Мянгат"-ын Regis Place гэдэг барилга байгууламжийн явган хүний замыг авто зам руу шахаж, ердөө 1.5 метр өчүүхэн зай гаргаж байгааг эсэргүүцэж байна. Автобусны буудлаас урагшаа алхахад яг тэнцүү байдлаар алхах орон зай гаргаж өгнө үү. Энэ ажлыг хийхэд нилээн хүч, эрх мэдэл орох байх. Өдөр тутам алхаж буй олон мянган иргэдийн эрх ашгийг бодоод энэ ажлыг хэрэгжүүлж өгөөрэй гэж хүсэх байна. Тэр өчүүхэн зайнд явган хүмүүс, дугуйтай хүмүүс, мопедтой хүмүүс ямар хэцүү, төвөгтэй, бухимдлаар өнгөрч байгааг нэг шалгаад үзээрэй. Яг нийтийн орон зайг Regis Place нь машины зогсоол болгосон бусармаг байдлыг залруулж өгнө үү.
- Мөнгөн завъяагаас Pease mall хүртэлх явган хүний замыг засахгүй, хавтанг хуулаад 14 хонолоо. Бороо ороход явган хүн зорчиход маш хүндрэлтэй байна. Хурдан янзлах хэрэгтэй байна. Уг асуудлыг холбогдох газарт нь уламжилж, арга хэмжээ авч өгнө үү.